



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ
ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

2020

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫН ТӨЛӨӨ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ /ИЛЧЛЭГЧ/-ИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ⁷³

УДИРТГАЛ

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн, судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар эрх зүйн орчинг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Хуулийн төслийн /цаашид “төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх тооцох аргачлал”-ын 1.4-т заасны дагуу:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Төсөл нь “нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулах эрх зүйн орчинг бий болгох” гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;

2. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

3. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь шалгана.

⁷³ Энэхүү үнэлгээг АТГ-ын захиалгаар 2020 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал нар хамтран гүйцэтгэв.

Хүснэгт 1. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан шалгуур үзүүлэлт

Д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийг сонгох
5.	Зорилгод байдал хүрэх	“Зорилгод хүрэх байдал” нь тухайн хуулийн төслөөр тавьж байгаа зорилгодоо хүрч чадах эсэхийг тооцон судалдаг шалгуур үзүүлэлт юм. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт, арга хэмжээнүүд нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэлэхэд ашиглана. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /цаашид “АТҮХ” гэх/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох”-оор заасан төдийгүй манай улсын тухайд иргэд гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан байдаг боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах талаар зохицуулалт хангалтгүй тусгасан, мөн 2006 онд батлагдсан Авлигын эсрэг хуульд албан хаагч авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газар /цаашид “АТГ” гэх/-т мэдээлэх үүрэгтэй байхаар, иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар АТГ-т өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгч болохоор заасан ба мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах талаар зохицуулалт мөн л хангалттай тусгагддаггүй тул төслийн үзэл баримтлалд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгох анхдагч хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзжээ. Иймд төслийн хүрээнд эдгээр асуудлыг шийдвэрлэсэн эсэх, сонгож авсан шийдлийн зорилгод хүрэх байдлыг үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
6.	Ойлгомжтой байдал	“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэхийг шалгана. Энэхүү хуулийн төсөл нь анхдагч төсөл учраас зохицуулалтын уялдаа, холбоо болон бусад хууль тогтоомжийн стандартыг хангаж буй эсэхийг хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх талаас нь үнэлэх нь зүйтэй гэж үзлээ.
7.	Харилцан уялдаа	“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг шалгах тохиолдолд хуулийн төслийн тодорхой зүйл, заалтыг бус хуулийн төслийг бүхэлд нь шалгана. Учир нь “Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн бусад хуультай нийцэх байдлыг шалгадаг. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулах талаар зөвлөмж өгөхөд чиглэсэн тул энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд шалгаж үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Манай орны хувьд иргэд гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг төлбөртэй авах талаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан байдаг боловч мэдээлэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх боломж нөхцөлөөр хангах талаар зохицуулалт хангалтгүй байна⁷⁴ гэж Нийтийн

⁷⁴ Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 1 дэх тал.

ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурджээ.

Дээрхээс үзвэл, төслийн үндсэн зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхийг авлигын асуудалтай холбон авч үзэж, шүгэл үлээгч /илчлэгчийг/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулахад оршиж байна.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд хуулийн төсөл боловсруулагчид дараах зорилтын хүрээнд төслийг боловсруулжээ. Үүнд:

- Хуулийн төслөөр зохицуулах харилцаа нь харьцангуй шинэ тул хуулийн төсөлд хэрэглэх зарим нэр томъёог тайлбарлах;
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалахтай холбоотойгоор бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлж хариуцах байгууллагыг тусгаж, чиг үүргийг тодорхойлох;
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээг нарийвчлан тусгах;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах асуудлыг зохицуулах;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ээс өгсөн мэдээллийн мөрөөр шагнал, урамшуулал олгохыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах;
- Хуулийг хэрэгжүүлэх явцад хүн гүтгэх, хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлж, шүгэл үлээсэн гэж үзэхгүй байх нөхцөлийг тодорхойлох;
- Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах, урамшуулах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлж, авлигатай тэмцэх ажиллагаанд ахиц гаргах эерэг нөлөөллийг тооцох;
- Хариуцлагын асуудлыг холбогдох хуультай нийцүүлэн тогтоох гэх мэт.

Дээрх зорилтуудыг багцлан харвал ямар асуудлыг шүгэл үлээсэнд тооцох, шүгэл үлээгчийн шүгэл үлээж буй үйл ажиллагааг дэмжих, түүнийг шүгэл үлээснийх нь төлөө аливаа эрсдэлээс хамгаалах, мөн тодорхой хэмжээгээр шагнаж урамшуулах цогц арга хэмжээг зохицуулахаар байна.

Иймд хуулийн төслийн “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцохын тулд дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах	Төслийн зүйл, заалтад бүхэлд нь.
2	Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох	Төслийн 5 дугаар зүйл 5.1-5.4, 6 дугаар зүйл 6.1 дэх хэсэг.
3	Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх	Төслийн 16 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, 23 дугаар 2, 3 дахь хэсэг.

2.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 5 бүлэг, 26 зүйлтэй/

2.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 5 бүлэг, 26 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.
3.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

3.1.1. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах” эхний зорилтын хувьд:

Хууль тогтоомжийн тухай хуульд “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна”⁷⁵ гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 33 дугаар зүйлд “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаархи аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ.”⁷⁶ гэж тусгасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор АТҮХ-ийг, Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан бөгөөд төлөвлөгөөнд “Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж заажээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 38 дугаар зарлигаар 2018-2019 оныг “Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил” болгон зарлаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж илчилсэн мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах зэрэг асуудалд

⁷⁵ Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25.

⁷⁶ Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг соёрхон батлах тухай. <https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>

тусгайлан анхаарч, хууль, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсөн.⁷⁷

Дээрх үндэслэл шаардлагын дагуу хуулийн төсөл санаачлагчид Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн холбогдох заалттай уг хуулийн төслийн агуулга, нэр томъёог нийцүүлж боловсруулсан байна.

Төслийн үзэл баримтлалд дурдсан үндэслэл, шаардлагын үүднээс тус хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага бий гэдэг нь тодорхой харагдаж байгаа төдийгүй энэ талаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн “Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны тайланд⁷⁸ хууль зүйн болон практик шаардлагын талаар дэлгэрэнгүй тайларласан байна. Тухайлбал, тус судалгаанд “Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна. Олон улсын судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн салбарт үйлдэгдсэн луйврын хэргийн 45 орчим хувийг салбар дотроос мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан илрүүлсэн байдаг. Зохисгүй үйлдэл, гэмт үйлдлийг дотооддоо мэдээлэх буюу шүгэл үлээх боломжийг бүрдүүлж, хөхүүлэн дэмжихийн чухлыг эндээс харж болно.⁷⁹ Мөн нийтийн ашиг сонирхлын төлөө зүй бус үйлдлийг мэдээлж, шүгэл үлээхийг ардчилсан нийгэмд иргэний хүлээх ёстой үүрэг гэж үздэг. Гэтэл Монгол Улсад зүй бус үйлдлийн талаар шүгэл үлээсэн иргэнийг хамгаалах механизм бүрдээгүйн улмаас үйлдэл, эс үйлдэхгүйг мэдээлсний дараа гарах эрсдэлээс болгоомжлон иргэд мэдээлэл өгдөггүй, өгөхийг хүсдэггүй байдал ажиглагдаж байна”⁸⁰ гэж тэмдэглээд эдгээр эрсдэл үүсгэж болохоор асуудлыг дараах байдлаар багцлан авч үзжээ. Үүнд⁸¹:

- Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа хууль бус үйлдлийг илчилж үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан, төрийн байгууллага, этгээдэд хандсаныхаа төлөө бусдын халдлага, дарамт шахалтад өртөх, гадуурхагдах;
- Бусдын зүгээс илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь халдах, цахим хэлбэрээр доромжлох, сэтгэл санааны дарамт үзүүлэх,
- Илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн гэр бүлийн гишүүдийг хөнөөлтэй нөхцөл байдал, сүрдүүлэг, сэтгэл санааны болон бие махбодийн дарамт, эрх чөлөө, амь зуулгад халдах;
- Нийгэмд шударга бус аливаа явдалтай тэмцвэл хохирдог гэсэн ойлголт нэмэгдсэнээр төрийн байгууллагын ажилтан, олон нийтийн төлөөлөл, хувь хүмүүс хууль бус үйлдлийг хараагүй мэт өнгөрүүлж, улмаар тэр үйлдэлд нь татагдан орох;
- Гадны хууль ёсны хөрөнгө оруулалт буурах, гадны хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх, улсын хөгжил, бүтээн байгуулалт нэмэгдэхгүй байх, улсын

⁷⁷ Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

⁷⁸ Дэлгэрэнгүйг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2019 онд гүйцэтгэсэн “Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны тайлангаас үзнэ үү.

⁷⁹ Дам ишлэв. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, (УБ, 2018), 146 дахь тал

⁸⁰ Дам шилэв. “Шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийг хамгаалах” хуулийн төслийн талаар зөвлөлдөх уулзалт. <http://parliament.mn/n/fxjo> (сүүлд үзсэн 2019.10.15)

⁸¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандан судалгааны тайлан, УБ., 2019 он, 10 дахь тал.

хөрөнгийг зүй бусаар зарцуулах нь нэмэгдэж алдагдалд орох;

- Төрийн байгууллагын хүнд суртал, авлига, хээл хахууль өндөр түвшинд шилжиж, сургуулийн багш болон бусад үйлчилгээний ажилтнуудын хууль бус жижиг үйлдэл халхавч болж буй байдал;
- Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтны зүгээс хууль бус мэдээллээ нууцлах, мэдээллээр хангах үүргээ биелүүлэхээс татгалзах, зайлсхийх, мэдээллийг нуун дарагдуулах зэрэг.

Эдгээр асуудлыг харгалзан шүгэл үлээгчийг хамгаалах нэгдсэн тогтолцоог **хууль тогтоомжоор бий болгох** замаар дээр дурдсан бүх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзжээ.

Иймд судлаачдын зүгээс энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд “Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах” гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

3.1.2. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох” зорилтын хувьд:

5 дугаар зүйл.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг

5.1.Байгууллага нь нийтийн ашиг сонирхол хохирохоос урьдчилан сэргийлэх, энэ талаар зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг /цаашид “шүгэл үлээгч” гэх/ дэмжих, хамгаалах үүрэгтэй.

5.2.Захиргааны байгууллага нь хувийн хэвшил, төрийн бус байгууллагын зүгээс нийтийн ашиг сонирхлыг хохирохоос урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж болно.

5.3.Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч нь ажил мэргэжлээ солих, албан тушаалаа өөрчлөх, түр хугацаагаар өөр үүрэг гүйцэтгэх зэрэг хүний нөөц, ажлын байртай холбоотой арга хэмжээ авах үндэслэл бүхий хүсэлт гаргавал тэрхүү хүсэлтийг тухайн байгууллагын удирдлага даруй шийдвэрлэнэ.

5.4.Байгууллага нь энэ хуулийн зохицуулалтад нийцүүлэн нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам гаргаж мөрдөнө.

6 дугаар зүйл.Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ авах

6.1.Авлигатай тэмцэх газар нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараахь асуудлаар арга хэмжээ авч, удирдамж, зөвлөмж гаргаж ажиллана:

6.1.1.нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах;

6.1.2.мэргэжлийн хяналт шалгалт явуулах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагатай харилцан хамтран ажиллах;

6.1.3.шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах;

6.1.4.шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох, урамшуулах, нөхөн төлбөр олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх;

6.1.5.олон нийтэд шүгэл үлээгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжихтэй холбоотой сургалт, сурталчилгаа явуулах;

6.1.6.шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;

6.1.7.хуульд заасан бусад.

Хууль тогтоомжийн тухай хууль⁸² /цаашид “ХТТХ” гэх/-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.11-д “хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана” гэж заасан.

Энэ хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг

⁸² Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25

сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино” гэж хуулийн зорилтыг тодорхойлжээ. Үүнийг багцлан авч үзвэл 5 зорилтын хүрээнд шүгэл үлээгчтэй холбоотой харилцааг зохицуулахаар тусгагдсан байна. Үүнд:

- 1/шүгэл үлээгчийг дэмжих;
- 2/ шүгэл үлээгчийг хамгаалах;
- 3/ шүгэл үлээгчийг урамшуулах;
- 4/ шүгэл үлээхэд тавигдах шаардлагыг тодорхойлох;
- 5/ шүгэл үлээх журмыг тодорхойлох зэрэг болно.

Төсөлд **“шүгэл үлээгчийг хамгаалах, урамшуулах, шүгэл үлээхэд тавигдах шаардлага”**-ыг тус бүрд нь бүлэг болгон тусгаж өгсөн атал **“шүгэл үлээгчийг дэмжих”** зохицуулалтыг хуулийн нийтлэг үндэслэл болох нэгдүгээр бүлэгт хамааруулан тусгажээ. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2.5 дахь заалтад “зүйлүүдийг сэдвээр нь бүлэглэж, бүлгийг хэсэг, ангид нэгтгэж болно” гэсэн төслийн бүтцийн шаардлагыг хангаагүй, мөн тус хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг⁸³-т заасан хуулийн төслийн бүтцийн дарааллыг баримтлаагүй байна гэж үзэж болохоор байна.

Иймд хуулийн зорилго, зорилт, үзэл баримтлалаасаа ч харсан **“шүгэл үлээгчийг дэмжих”** зохицуулалтыг тусгай бүлэг болгон оруулах нь зүйтэй.

Төслийн 5 дугаар зүйлд шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байгууллага бүрд /захиргааны, хувийн хэвшлийн, төрийн бус байгууллага гэх мэт/ үүрэг болгосон зохицуулалтыг тусгажээ. Энэ нь нэг талаар шүгэл үлээгчийн сэтгэл зүйд сайнаар нөлөөлөх, айдсыг багасгах, шүгэл үлээх сэдлийг төрүүлэхэд дэмжлэг болохоос гадна, нөгөө талаар шүгэл үлээх үйл ажиллагааг дэмжих, авлигыг бууруулахад түлхэц болохуйц сайшаалтай зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Мөн байгууллага бүрийг нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн талаар зөв хандлага төлөвшүүлэх сургалт явуулах, шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийг дэмжих, урамшуулах, хамгаалах асуудлыг тусгасан журам баталж, мөрдүүлэхээр заасан нь процесс ажиллагааг улам тодорхой болгосон зохицуулалт болжээ.

Харин хуулийн төслөөс харахад байгууллага бүрд үүрэг ногдуулсан хэдий ч АТГ-т бусад байгууллагаас илүү өргөн хүрээнд харьцангуй олон арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг ногдуулсан байна. Тухайлбал, шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах, шүгэл үлээгчид мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ.

Төслөөр АТГ болон бусад байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг тус тусад нь зүйл, заалт болгон тусгахыг оролдсон нь харагдаж байгаа хэдий ч зарим зүйл, заалтын хувьд давхардуулсан, ойлгомжгүй байдал үүсгэсэн зохицуулалт цөөнгүй байна. Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлд АТГ-ын хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан бөгөөд 6 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад “нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн мэдээллийг хүлээн авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл үнэн эсэх, шүгэл үлээж байгаа зорилго нь нийтийн ашиг сонирхлын төлөө эсэхийг хянах” гэж заасан нь энэхүү арга хэмжээг зөвхөн АТГ хэрэгжүүлнэ гэж ойлгогдож байна.

Гэтэл төслийн “Мэдээллийг бүртгэх, шилжүүлэх, хянан шалгах” хэмээх 11 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “Авлигатай тэмцэх газар болон энэ хуулийн 9.1-

⁸³ Мөн тэнд, “Хуулийн төслийн бүтцийг дараах дарааллаар байрлуулна:

1/хуулийн төслийн гарчиг, 2/нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн “ерөнхий анги”, эсхүл “нийтлэг үндэслэл” гэсэн бүлэг, хэсэг, 3/нэр томъёоны тайлбар, 4/тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн тусгай “анги”, эсхүл агуулгаар нь бүлэг, хэсэг болгосон эрх зүйн хэм хэмжээ, 5/ ...”.

д заасан байгууллага, албан тушаалтан нь шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авч ажлын таван өдөрт багтаан дараах асуудлыг тодруулж, шаардлагатай гэж үзвэл шүгэл үлээгчээс нэмэлт мэдээлэл хүсч болно” гээд энэхүү тодруулах асуудалд нь “энэ хуулийн 8.2.3-т заасан мэдээлэл үнэн, зөв эсэх;”⁸⁴, мөн “шүгэл үлээсэн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлын төлөө гэж үзэх үндэслэл байгаа эсэх”⁸⁵ гэж заасан нь хуулийн төслөөр зааж өгсөн холбогдох байгууллагууд бүрд хэрэгжүүлэх арга хэмжээ байхаар харагдаж байна.

Иймд төсөлд АТГ-ын онцлог хэрэгжүүлэх арга хэмжээг 6 дугаар зүйлээр, бусад байгууллагын нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээг 11 дүгээр зүйлээр зохицуулахаар давхардуулахгүйгээр тусгаж өгөх нь зүйтэй болов уу.

Төслийн 5, 6 дугаар зүйлээс харахад шүгэл үлээгчийг дэмжих талаар холбогдох байгууллагууд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тэдэнд урамшуулал, мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ зохион байгуулах, мөн хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээний талаар тусгасан нь сайшаалтай төдийгүй эдгээр арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох журмыг байгууллагууд журамлан мөрдүүлэхээр заасан нь төслөөр тавьсан “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох” гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

3.1.3. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх” зорилтын хувьд:

ГУРАВДУГААР БҮЛЭГ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ 16 дугаар зүйл. Шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах 16.4. Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно. 16.5. Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно. 16.6. Шүгэл үлээсэн мэдээллийн дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч болж байгаа шүгэл үлээгчийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамруулж болно. 19 дүгээр зүйл. Шүгэл үлээгчийг дарамт, шахалтаас хамгаалах 19.3. Хяналт шалгалтаар шүгэл үлээгчид дарамт шахалт үзүүлэх үйлдэл хийх нь илэрхий болсон тохиолдолд холбогдох этгээдэд хандаж Авилгатай тэмцэх газраас тухайн үйлдлийг хийхгүй байх талаар зөвлөмж хүргүүлнэ. 19.6. Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД МӨНГӨН ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ, НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ 23 дугаар зүйл. Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох 23.2. Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй. 23.3. Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.

⁸⁴ Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, 11.1.1.

⁸⁵ Мөн тэнд, 11.1.2.

Төслийн Гуравдугаар бүлгийн 13-19 дүгээр зүйлд шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах зохицуулалтыг, Дөрөвдүгээр бүлгийн 20-24 дүгээр зүйлд шүгэл үлээгчид шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох асуудлыг цогц байдлаар тусгажээ.

Энэ хэсэгт сонгон авсан зүйл заалтуудын өөр хоорондын харилцан уялдаа хийгээд бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа байдал талаас нь зорилтыг үнэлнэ.

Төслөөр шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль /цаашид “ГХХтХ” гэх/ болон холблгдох бусад хуультай уялдуулан зохицуулсан бөгөөд бусад хуулийн зүйл, заалтыг иш татахдаа алдаа, дутагдал нэлээд гаргасан байгаа нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал,

Төслийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно” гэсэн нь уг заалтаар илэрхийлэх гээд буй ойлголтыг буруу илэрхийлсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, уг заалтад “... Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу ...” гэж тодотгож заасан зохицуулалтыг ГХХтХ-иас харвал “Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт ээлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно”⁸⁶ гэснээс харахад шүгэл үлээгч тус хуулиар хамгаалагдаж болно гэсэн утга санааг илэрхийлснээс бус ямар журмын дагуу хамгаалагдах талаар тусгаагүй заалт тул хуулийн зүйл, заалтыг буруу ишэлсэн гэж үзэж болохоор байна.

Иймд төслийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Шүгэл үлээгчийн хүсэлтийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасныг үндэслэн тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно” гэж өөрчлөн, найруулж болох юм.

Мөн төслийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт ЗШШТХ-ийн зүйл, заалтыг буруу ишэлсэн байна. Өөрөөр хэлбэл, ЗШШТХ-ийн 6.2 дугаар зүйлд “8” гэсэн хэсэг байхгүй бөгөөд хуулийн төсөл санаачлагчид тус хуулийн 6.2 дугаар зүйлийн “6” дахь хэсгийг иш татаж бичих байсан болов уу.

Түүнчлэн, төслийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг иш татан бичсэн “... Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ЭХХШТХ” гэх/-ийн 13.1, 13.2-т заасны дагуу ...” гэснээс харахад ГХХтХ-д 13.2 гэсэн зүйл, заалт байхгүй, ЭХХШТХ-ийн 13.2⁸⁷ дугаар зүйлийг ишлэх шаардлагагүй байхаар харагдаж байна.

Иймд эдгээр зүйл, заалтыг дахин нягтлах шаардлагатай юм.

Төслийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хяналт шалгалтаар шүгэл үлээгчид дарамт шахалт үзүүлэх үйлдэл хийх нь илэрхий болсон тохиолдолд холбогдох этгээдэд хандаж Авилгатай тэмцэх газраас тухайн үйлдлийг хийхгүй байх талаар

⁸⁶ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2013 он, №30.

⁸⁷ ЭХХШТХ-ийн 13.2 дугаар зүйл. Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэр гаргах

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

1.1.аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;

1.2.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;

1.3.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;

1.4.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

2.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандана.

3.Шүүх нь прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу авч болно.

зөвлөмж хүргүүлнэ” гээд энэхүү хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд дараагийн авах арга хэмжээг тусгаж өгөөгүй байна. Энэ байдал нь шүгэл үлээгчид цаашдаа хохирол үүсгэж болзошгүй байх тул АТГ-ын зөвлөмжийг биелүүлээгүй бол тус газраас ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Шүгэл үлээгчид **дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь** Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор **энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд** шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ” гэж заажээ.

Гэтэл тус хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тухайн дарамт, шахалт үзүүлсэн байгууллага, албан тушаалтан нь:

- дарамт шахалт үзүүлсэн үйлдлийг цуцлах, буюу хориглох;
- дутуу олгосон эсхүл огт олгоогүй цалин хөлс, урамшууллыг нөхөн олгох;
- сахилгын болон захиргааны, эдийн засгийн бусад сөрөг арга хэмжээг хүчингүй болгох;
- зохих ажлын байр, албан тушаалд нь томилох, бусад гэх мэт арга хэмжээг даруй авах ёстой гэж заасан.

Тэгвэл, дээрх арга хэмжээнүүд нь байгууллагын эрх бүхий албан тушаалтан, өөрөөр хэлбэл, удирдах албан тушаалтны шийдвэрээр авах арга хэмжээнүүд юм.

Эндээс үзэхэд төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг “**зөвхөн дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь эдгээр арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлэхээр заасан**” гэж ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, дээрх арга хэмжээг авах эрх бүхий субъект /удирдах албан тушаалтан/ л дарамт, шахалт үзүүлсэн тохиолдлын тухай яригдаж байгаа болохоос тухайн байгууллагын гүйцэтгэх албан тушаалтан шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.

Иймд энэхүү зохицуулалтыг эргэн нягтлах шаардлагатай юм.

Мөн төслийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн дагуу олгох мөнгөн шагнал, урамшууллын хэмжээ нь бусад хууль тогтоомжийн дагуу адил үндэслэл, шалтгаанаар олгох **мөнгөн шагнал, урамшууллын хэмжээтэй тэнцүү, эсхүл уг хэмжээнээс бага буюу илүү байх нөхцөлд Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага уг зөрүүг хасч, нэмж тооцон олгохгүй**” гэж заасан нь ямар тохиолдолд, аль ч байгууллагаас олгож буй шагнал, урамшууллын хэмжээ зөрүүтэй байсан ч нэмж, хасч тооцохгүй гэж ойлгогдож байна. Гэтэл төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүгэл үлээгч энэ хуульд заасантай адил үндэслэл, шалтгаанаар бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшууллын мөнгө авсан тохиолдолд **Авлигатай тэмцэх газар болон холбогдох байгууллага тэрхүү авсан хэмжээгээр мөнгөн шагнал, урамшууллын мөнгөн дүнгээс хасч тооцно.**” гэж заасан нь хоорондоо зөрчил үүсгэж байх тул төслийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг хасах нь зүйтэй болов уу.

Иймд төслөөр тавьсан “Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх” гэсэн зорилтдоо хангалттай хүрээгүй гэж үзэж болохоор байна.

3.2. Ойлгомжтой байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн⁸⁸/цаашид “ХТтХ” гэх/ 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

⁸⁸ Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015 он, №25.

Хүснэгт 4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Төслийн 13.3-т "...Шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэл нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй болохыг тогтоосон нь тухайн шүгэл үлээгчийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй... " гэж заасан нь учир дутагдалтай байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т "...Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй..." гэж заасан. Гэтэл шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхолд хамаарахгүй тухайн иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, сэтгэл санаанд хохирол учруулсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл байхад тус хуулийн төсөлд Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль болон бусад хуульд заасан хариуцлагад татахгүй гэж заасан нь шүгэл үлээгчийн шүгэл үлээсэн үйлдлийн улмаас бусад этгээд хохирсон ч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг хязгаарласан зохицуулалт болсон байна.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэд хэдэн тохиолдол илэрсэн бөгөөд энэ талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэ талаар судалгааны зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9. Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагалдан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ. Өөрөөр хэлбэл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.10-д заасан шаардлагыг зөрчсөн асуудал тогтоогдоогүй болно.
29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Төслийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилтыг "...Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино" гэж тодорхойлсон байна.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулганд тавих нийтлэг шаардлага.	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Төслийн 3.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.2-т заасныг; 3.1.3."хамаарал бүхий этгээд" гэж Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг; 3.1.4."даруй" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7-д заасныг тус тус ойлгохоор заасан нь бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.
30.1.2.Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Төслийн нэр буюу "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай" гэснийг "... <i>Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай</i> " гэж; Төслийн 7.3, 7.4, 10.4, 19.3-т заасан "...Авилгатай тэмцэх..." гэснийг "... <i>Авилгатай тэмцэх...</i> " гэж; Төслийн 3.1.3-т "...Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг..." гэснийг "... <i>Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.3-т заасныг...</i> " гэж; Төслийн 5.1-д "...нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг /цаашид "шүгэл үлээгч" гэх/ гэжээ. Иймд тус төслийн 5.3, 5.4, 6.1, 6.1.1, 8.1, 10.1-д заасан "...нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч..." гэснийг "... <i>шүгэл үлээгч...</i> " гэж;

	Төслийн 5.3, 8.1, 10.1-д заасан "... нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч..." гэснийг <i>"...шүгэл үлээгч..."</i> гэж; Төслийн 11.6-д "...Зохих хяналт, шалгалтаар шүгэл үлээсэн мэдээлэл нь батлагдаагүй..." гэж заасны <i>"...мэдээлэл..."</i> гэдгийг <i>"...мэдээлэл..."</i> гэж; Төслийн 20.2-т "...Энэ хуулийн 20.1-д зааснаар мөнгөн шагнал авах өргөдөл ирүүлснээс хойш долоо хоногийн дотор Авлигатай тэмцэх газраас Мөнгөн шагнал олгох зөвлөл байгуулах ба уг зөвлөлөөс хэлэлцэн шийдвэрлэсний дагуу дараахь хэмжээг баримтлан мөнгөн шагнал олгоно..." гэж заасны дагуу дор дурдсан хүснэгтэд нь мөнгөн шагнал олгох хувь хэмжээг зааж өгсөн. Тус хүснэгт дэх "Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/" гэсэн багана доорх хүснэгтэн дэх үнийн дүнг ойлгомжтой байлгахын тулд дор дурдсан байдлаар өөрчилж болох юм. 1. "...50 саяас 250 сая..." гэснийг <i>"...50 саяас 250 сая хүртэл..."</i> гэж; 2. "...250 саяас 1 тэрбум..." гэснийг <i>"...250 саяас 1 тэрбум хүртэл..."</i> гэж; 3. "...1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум..." гэснийг <i>"...1 тэрбум төгрөгөөс 2 тэрбум хүртэл..."</i> гэж; Төслийн 7.5-д "...дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлж байна..." гэснийг "...дэлгэрэнгүй мэдээллийг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мөн хугацаанд хүргүүлнэ..." гэж тус тус өөрчлөх; Төслийн 9.1.2-т "...нийтийн ашиг сонирхолтой холбоотой тухайн асуудал эрхлэх асуудлын хүрээнд нь хамаарах байгууллагын удирдах албан тушаалтанд..." гэдгийг утга зүйн хувьд найруулах; Төслийн 11.7-д заасан "... удаа дараа..." гэснийг хэдэн удаагийн үйлдэл гэж ойлгох талаар тусгаагүй байна. иймд эргэлзээтэй нөхцөл байдал үүсгэхээс сэргийлж "удаа дараа" гэж бичилгүй <i>".... /тоон утга/ ба түүнээс дээш удаа"</i> гэж бичих; Төслийн 12.1.4-т "...нийтийн ашиг сонирхлыг хохироосон үйлдлийг холбогдох хуулийн дагуу хянан шалгаж эхэлчихсэн байсан буюу шалгаж дууссан бол..." гэснийг өөрчлөн найруулах; Төслийн 14.2-т "...Шүгэл үлээгч энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтийг Авлигатай тэмцэх газарт гаргах ба тухайн байгууллага зөвлөгөө өгөх ажлыг хүсэлтийг хүлээн авснаас хойш даруй зохион байгуулна..." гэснийг <i>"...Шүгэл үлээгч нь энэ хуулийн 14.1-д заасан зөвлөгөө авах тухай хүсэлтээ Авлигатай тэмцэх газарт гаргах бөгөөд хүсэлтийг хүлээн авсан даруй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна..."</i> гэж өөрчлөн найруулах; Төслийн 16.4-т "...Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5.4-т заасны дагуу тухайн хуульд заасан журмаар хамгаалалтын арга хэмжээ авч болно..." гэснийг <i>"...Шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хамгаалалтын арга хэмжээ авч болно"</i> гэж өөрчлөн найруулах; Төслийн 18.1-д "...Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан шүгэл үлээгчид дараахь дарамт шахалт үзүүлэхийг хориглоно..." гэснээс харахад тодорхой хугацаа заагаагүй байна. Өөрөөр хэлбэл, шүгэл үлээгч хэдий хэр хугацаа өнгөрсний дараа ч өөрт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэнтэй нь холбогдуулан дарамт шахалт үзүүлсэн гэж гомдол гаргах эрхтэй байна. Иймд энэхүү зохицуулалтад хугацаа зааж өгөх; Төслийн 18.2-т заасан зохицуулалтыг хууль зүйн нэр томъёо ашиглан найруулах бичих;
--	---

	Төслийн 19.4-т “...гомдлыг Авлигатай тэмцэх газар хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор энэхүү хууль бус үйлдлийн үр дагаврыг арилгах талаар зөвлөмж өгөх ба зөвлөмжийн дагуу тухайн байгууллага, албан тушаалтан дараахь арга хэмжээг даруй авна...” гэж заажээ. Тус зохицуулалтад заасан “... энэхүү хууль бус үйлдлийн үр дагаврыг арилгах” гэснийг өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь шүгэл үлээгчийн гомдлыг хүлээн аваад тус гомдол гаргасан үйлдлийг шууд хууль бус гэж дүгнэх мэтээр харагдаж байна. Төслийн 19.4-т “...зөвлөмж өгөх ба зөвлөмжийн дагуу тухайн байгууллага, албан тушаалтан дараахь арга хэмжээг даруй авна” гэж заажээ. Харин төслийн 19.6-д “...Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд нь Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 19.4-т заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд шүгэл үлээгч холбогдох хуулийн дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ” гэж заажээ. Дээрх хоёр зохицуулалт нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий заалт байх тул 19.6-д заасан зохицуулалтыг 19.5 болгон өөрчилж, байрыг нь солих. Мөн тус зохицуулалтаас “...Шүгэл үлээгчид дарамт, шахалт үзүүлсэн этгээд...” гэсэн хэсгийг хасаж, “...Тухайн байгууллага, албан тушаалтан нь...” гэж найруулан бичвэл тус зохицуулалтыг илүү ойлгомжтой болгохоор байна. Төслийн 19.7-д “...Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ...” гэж заасныг “...тогтмол хяналт тавин ажиллана...” гэж өөрчлөх. Төслийн 23 дугаар зүйлийг өөрчлөн найруулах. Учир нь тус зүйл нь “Мөнгөн шагналыг давхардуулан олгохыг хориглох” гэсэн гарчигтай боловч зохицуулалтууд нь мөнгөн шагнал, урамшууллыг давхардуулан олгохыг хориглосон байна. Мөн төслийн 23.2, 23.3-т заасан зохицуулалтууд нь өөр хоорондоо зөрчилтэй⁸⁹ төдийгүй хэт нуршуу байдлаар бичигджээ. Тухайлбал, төслийн 23.1-д “... энэ хуулийн 20, 21 дүгээр зүйлд заасан этгээд энэ хуульд заасантай адил үндэслэлээр бусад хууль тогтоомжийн дагуу мөнгөн шагнал, урамшуулал авахыг хориглоно” гэж бичих нь зүйтэй. Төслийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн найруулгыг засах.
30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Төслийн 19.4.2-т “...дутуу олгосон эсхүл огт олгоогүй цалин хөлс, урамшууллыг нөхөн олгох...” гэж заасан. Тус зохицуулалт дахь “...огт олгоогүй...” гэсэн нь “...олгоогүй...” гэдэг үгэнд хүч оруулсан буюу хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байна. Төслийн 19.7-д “...Авлигатай тэмцэх газар хоёр жилийн турш тогтмол мониторинг хийнэ” гэж заасан. Тус зохицуулалт дахь “...хоёр жилийн турш ...” гэсэн нь “хоёр жилийн...” гэдэг үгэнд хүч оруулсан нэр томьёог хэрэглэсэн байна. Зүй нь “...хоёр жилийн хугацаанд тогтмол...” гэж бичих.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.3. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

⁸⁹ Дэлгэрэнгүйг харилцан уялдаа хэсгийн “Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх” хэсгээс үзнэ үү.

Хүснэгт 5. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилт нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих, хамгаалах, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд тавигдах шаардлага, шүгэл үлээх журмыг тодорхойлоход оршино гэж заасан. Хуулийн төслийн нэгдүгээр бүлгийн 5, 6 дугаар зүйлд /шүгэл үлээгчийг дэмжих талаар/, хоёрдугаар бүлгийн 8 дугаар зүйлд /шүгэл үлээхэд тавигдах шаардлагыг, тус бүлгийн 9-12 дугаар зүйлд /шүгэл үлээх журмын талаар/, гуравдугаар бүлэгт /шүгэл үлээгчийг хамгаалах/, дөрөвдүгээр бүлэгт /шүгэл үлээгчид мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох асуудлыг/ тус тус тусгаснаас харахад төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцсэн байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн үзэл баримтлалд "...Авлигын асуудлыг нийтийн ашиг сонирхлоос ангид авч үзэх боломжгүй юм. Иймд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодорхойлсон холбогдох судалгааны үр дүнг болон энэ талаарх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор төр засгийн зүгээс шийдвэрлэж, чиглэлийг тодорхойлсны дагуу Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсрууллаа" гэжээ. Гэвч хуулийн төслийн нэрнээс харахад "нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах" гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, массын сайн сайхны төлөө шүгэл үлээгчийг хамгаалах мэт ойлгогдож байна. Иймд төслийн нэрийг "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах" эсвэл "Шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах гэж найруулах нь зүйтэй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Төслийн Дөрөвдүгээр бүлэг "Шүгэл үлээгчид мөнгөн шагнал, урамшуулал, нөхөн төлбөр олгох" тухай зохицуулалтыг тусгажээ. Ийнхүү тусгахдаа тус төслийн 20 дугаар зүйлд "...Шүгэл үлээгчид мөнгөн шагнал олгох", 21 дүгээр зүйлд "...Шүгэл үлээгчид урамшуулал олгох", 22 дугаар зүйлд "...Шүгэл үлээгчид нөхөн төлбөр олгох" тухай тус тус зохицуулжээ. Хуулийн нэр томъёо хэсэгт мөнгөн шагнал, урамшууллыг тодорхойлох нь зүйтэй. Мөн төслийн 11.7-д "... олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно..." гэж заасныг сайтар нягтлан үзэх нь зүйтэй. Учир нь Монгол Улсын бусад хууль тогтоомж, тухайлбал, Зөрчлийн тухай хууль, Компани тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай гэх мэт хуулиудад "...олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл..." гэж заасан байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо зөрчилтэй байгаа талаар Төслийн 23 дугаар зүйл нь "Мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглох" гэж заасан. Гэсэн хэдий ч 23.1, 23. 2, 23. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтуудад "... мөнгөн шагнал, урамшуулал..."-ын талаарх зохицуулалтыг агуулсан байна. Өөрөөр хэлбэл, 23 дугаар зүйлийн гарчиг нь зөвхөн мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглоход чиглэсэн мэт харагдаж байгаа боловч тус зүйл дэх зохицуулалтуудын агуулга нь мөнгөн шагнал, урамшуулалтай холбоотой зохицуулалтууд байна. Мөн төслийн 23.1-д "... мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно" гэж заасан нь зүйлийнхээ гарчигтай уялдахгүй байна. Учир нь "шаардах", "олгохгүй" байх гэдэг үгнүүд нь өөр хоорондоо агуулгын зөрүүг бий болгож байна. Төслийн 23.1, 23.2, 23.3-т заасан зохицуулалт нь тодорхой хэмжээгээр зүйлийнхээ гарчигтай зөрчилдөж байна. Төслийн 23 дугаар зүйлийн зохицуулалтууд өөр хоорондоо зөрчилтэй байна. Энэ талаар үнэлгээний зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд дэлгэрэнгүй бичигдсэн болно.

	Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо зөрчилтэй байгаа талаар Төслийн 20.1-д “...Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсний үр дүнд захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан олж авсан уг асуудлаар хууль зүйн үр дагавар бий болсон дараахь нөхцөлд шүгэл үлээгч мөнгөн шагнал авахаар Авлигатай тэмцэх газарт хандаж өргөдөл гаргаж болно” гэж заасан. Гэтэл төслийн 20.2 дахь хэсэгт заасан зохицуулалтын доорх хүснэгтэд “...Энэ хуулийн 20.1-д заасан орлогод хамаарах үнийн дүн /төгрөгөөр/...” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 20.1-д орлогын талаар заагаагүй төслийн 20.2-т заасан хүснэгтэд “...20.1-д заасан орлогод хамаарах...” гэж бичсэн нь учир дутагдалтай байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуультай зөрчилдөж байгаа талаар Төслийн 16.5-д “...Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн зөрчлийн талаар шүгэл үлээж, мэдээлэл өгсөн тохиолдолд шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 8-д заасны дагуу аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч болно...” гэж заасан бөгөөд ЗШШТХ-ийн 6.2 дугаар зүйлд “Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах журам”-ыг зааж өгсөн бөгөөд тус зүйлд “8 дахь хэсэг” хуульчлагдаагүй буюу 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгээр энэхүү зохицуулалт дуусаж байна. Өөрөөр хэлбэл, төслийн 16.5-д заасан заалт нь ЗШШТХ-тай уялдаагүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг хуульд тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Төслийн 3 дугаар зүйлд заасан хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт “... Нийтийн ашиг сонирхол”, “шүгэл үлээгч”, “шүгэл үлээсэн мэдээлэл” гэж юуг ойлгох талаар тайлбарлах
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслийн 6 болон 11 дүгээр зүйлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан байна. ⁹⁰
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой тусгай зохицуулалт тусгаагүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй байна.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

⁹⁰ Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү

Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг 25 дугаар зүйлийн 25.1-д "...Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж 25.2-т "...Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, хуулийн тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд дээр дурдсан хуулиар хариуцлага хүлээлгэхээр заажээ.
---	---

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Тус үнэлгээний хүрээнд захиалагч байгууллагаас хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх мэдээллийг ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээлэлд тулгуурлан судлаачдын зүгээс холбогдох хууль тогтоомж, судалгааны тайлан, гарын авлага зэргийг ашиглан үнэлгээг гүйцэтгэлээ.

Түүнчлэн энэхүү төсөл нь шинээр үүсч байгаа харилцааг зохицуулахаар боловсруулагдсан анхдагч хуулийн төсөл учраас практикт ямар үр дагавар үүсгэх талаар мэдээлэл өгөх боломжгүй тул тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг тодруулах шаардлагагүй гэж үзлээ.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Эдгээрийг сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

5. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үзэл баримтлалыг үзвэл гурван зорилт дэвшүүлсэн байх бөгөөд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тодруулбал, (1)Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах зорилтын хүрээнд төслийг бүхэлд нь, (2)Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох зорилтын хүрээнд Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих талаар байгууллагын хүлээх үүрэг, Авлигатай тэмцэх газраас шүгэл үлээгчийг дэмжих нэгдсэн арга хэмжээ авахтай холбогдсон зохицуулалтыг, (3) Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд шүгэл үлээгчийн хувийн аюулгүй байдлыг хамгаалах, түүнийг дарамт, шахалтаас хамгаалах, мөнгөн шагналыг давхардуулан олгохгүй байх талаарх зохицуулалтыг тус тус сонгон авч үнэллээ.

- Энэхүү анхдагч хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд "Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах" гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.
- Төслийн 5, 6 дугаар зүйлээс харахад шүгэл үлээгчийг дэмжих талаар холбогдох байгууллагууд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, тэдэнд урамшуулал, мөнгөн шагнал, нөхөн төлбөр олгох, аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ зохион байгуулах, мөн хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээний талаар тусгасан нь сайшаалтай төдийгүй эдгээр арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох журмыг байгууллагууд журамлан мөрдүүлэхээр заасан нь төслөөр тавьсан "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг дэмжих чиглэлээр АТГ болон бусад байгууллагын хүлээх

үүрэг, хэрэгжүүлэх ажиллагааг тодорхойлох” гэсэн зорилтдоо хүрсэн гэж үзэж болохоор байна.

- Иймд төслөөр тавьсан “Шүгэл үлээгчийн нийгэмд гүйцэтгэх үүргийг нийтэд зөв ойлгуулах, хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрдүүлэх, дэмжих, хамгаалах асуудлыг шийдвэрлэх” гэсэн зорилтдоо хангалтай хүрээгүй гэж үзэж болохоор байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд⁹¹:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэсэн, зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт;
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй зүйл, заалт;
- Хэл зүйн найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцээгүй зүйл, заалт тус тус нэлээд байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 7 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авлига хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 7 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа хэдий ч зарим анхаарах зүйл байна гэж дүгнэхээр байна. Энэ талаар үнэлгээний тайлангийн 1 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй бичигдсэн.
- Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн хэдий ч найруулгын хувьд засаж, сайжруулах шаардлагатай.
- Нэр томъёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томъёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, төслийн 11.7-д “... олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандаж болно...” гэж заасныг сайтар нягтлан үзэх нь зүйтэй. Учир нь Монгол Улсын бусад хууль тогтоомж, тухайлбал, Зөрчлийн тухай хууль, Компани тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай гэх мэт хуулиудад “...олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл...” гэж заасан байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, төслийн 23 дугаар зүйл нь “Мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглох” гэж заасан. Гэсэн хэдий ч 23.1, 23. 2, 23. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтуудад “... мөнгөн шагнал, урамшуулал...”-ын талаарх зохицуулалтыг агуулсан байна. Өөрөөр хэлбэл, 23 дугаар зүйлийн гарчиг нь зөвхөн мөнгөн шагнал давхардуулан олгохыг хориглоход чиглэсэн мэт харагдаж байгаа боловч тус зүйл дэх зохицуулалтуудын

⁹¹ Дэлгэрэнгүйг үнэлгээний тайлангийн “ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн хэсгээс үзнэ үү.

агуулга нь мөнгөн шагнал, урамшуулалтай холбоотой зохицуулалтууд байна. Мөн төслийн 23.1-д "... мөнгөн шагнал, урамшуулал шаардахыг хориглоно" гэж заасан нь зүйлийнхээ гарчигтай бүрэн уялдахгүй байна. Учир нь "шаардах", "олгохгүй" байх гэдэг үгнүүд нь өөр хоорондоо агуулгын зөрүүг бий болгож байна. Төслийн 23.1, 23.2, 23.3-т заасан зохицуулалт нь тодорхой хэмжээгээр зүйлийнхээ гарчигтай зөрчилдөж байна.

- Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан байж болзошгүй хэсэгт хэд хэдэн нэр томъёог тайлбарлах шаардлагатай гэж үзсэн.
- Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан гэж үзсэн. Тухайлбал, төслийн 6 болон 11 дүгээр зүйлийн зохицуулалт давхардсан гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Хуулийн нэрийг "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах тухай" гэж өөрчлөх;
- Хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт "нийтийн ашиг сонирхол", "шүгэл үлээгч", "шүгэл үлээсэн мэдээлэл", "мөнгөн шагнал", "урамшуулал", "хохиороох бодит нөхцөл бүрдсэн" гэж юуг ойлгох талаар тайлбарлах;
- "Шүгэл үлээгчийг дэмжих" зохицуулалтыг тусад нь бүлэг болгон тусгах;
- Төслөөр давхардуулан тусгасан зохицуулалтыг нэг мөр болгох. Тухайлбал, АТГ-ын онцлог хэрэгжүүлэх арга хэмжээг 6 дугаар зүйлээр, бусад байгууллагын нийтлэг хэрэгжүүлэх арга хэмжээг 11 дүгээр зүйлээр зохицуулах;
- Бусад хуулиас иш татсан зохицуулалтыг дахин нягтлах;
- Төслийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан АТГ-ын зөвлөмжийг биелүүлээгүй бол тус газраас ямар арга хэмжээ авах талаар нарийвчлан тусгах;
- төслийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийг бүхэлд нь дахин нягтлах ;
- Төслийн 6.1.7, 17.1.5, 19.4.5-д "... хуульд заасан бусад" гэж зааныг илүү тодорхой болгон аль болох "... хуульд заасан бусад" гэж бичихээс татгалзах;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл болон Монгол хэлний зөв бичих дүрмийг баримтлан үг үсэг, найруулгын алдааг засах зэрэг болно.

НОМ ЗҮЙ**Нэг. Монгол Улсын хууль, олон улсын гэрээ**

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №35
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013), №30
- Компанийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2011), №42
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28
- Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23
- Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), №23
- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 2003

Хоёр. Судалгааны тайлан, холбогдох эх сурвалж

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, 2019
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, 2018
- *Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг /илчлэгчийг/ хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2020*
- Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгч /илчлэгч/-ийг хамгаалах тухай хуулийн төсөл, 2020

Гурав. Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://www.legalinfo.mn/>
- “Шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийг хамгаалах” хуулийн төслийн талаар зөвлөлдөх уулзалт. <http://parliament.mn/n/fxjo>